



ТАТВАРЫН ТАЛААРХ ИЛЭН ДАЛАНГУЙ ЯРИА



УИХ-д өргөн барьсан хуулийн этгээдийн орлогын албан татварын хуулийн төслийн үзэл баримтлал

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тогтолцоог одоогийнхоос илүү боловсронгуй болгох зорилгоор Хуулийн этгээдийн орлогын албан татварын хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Нийтэд ойлгомжтой, өргөн хүрээг хамарсан хуулийн шинэ төсөл боловсруулснаар дээрх зорилтыг хангана гэж Засгийн газар үзлээ. Одоогийн мөрдөж буй хууль 1992 онд батлагдсанаас хойш нийт 20 шахам нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хэрэгжүүлэхэд түвэгтэй, хэд хэдэн утга санааг зэрэгцүүлэн тусгасан зэргээс үүдэн хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай болсон юм.

Хуулийн төсөлд дараах заалтуудыг тусгалаа.

- Хуулийн нэр томъёоны ойлголтыг нэг мөр ойлгох зорилгоор зарим нэр томъёог тайлбарлан тусгалаа. Одоогийн мөрдөж буй хуульд нэр томъёог тайлбарласан зүйл дутагдаж байгаа тул хуулийг ойлгож хэрэглэхэд түвэгтэй байгаа юм.
- Татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо хасагдахгүй зардлыг хуульд тусгасан байгааг өөрчилж хасагдах зардлыг илүүтэй тусгах юм. Хуулийн төсөлд одоогийн мөрдөж буй хуульд хязгаарласан болон хасагдахгүй зардалд тооцсон зарим зардлыг хасагдах зардалд оруулсан байна. Тухайлбал, ажиллагсад олгосон шагнал, урамшуулал, байр, орон сууцны хөлсний болон унаа, хоол, байр түлшний үнийн хөнгөлөлтийг хасагдах зардалд тооцно. Сайн дурын даатгалын хураамжийг хасагдах зардалд тооцох боловч татвар ногдох орлогын 15 хувиас хэтрэхгүй байх. Татвар ногдох орлогын 10 хувиар хязгаарлаж буй зар сурталчилгааны зардлыг бүрэн хасагдах зардалд тооцохоор хуулийн төсөлд тусгалаа.
- Одоогийн мөрдөж буй албан татварын хувь болох 15, 30 хувийг хэвээр үлдээж 30 хувийн албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг 100.0 сая байсныг 500.0 сая төгрөг болгон өөрчлөхөөр төсөлд тусгав. Энэ нь аж ахуйн нэгж, байгууллагын өсөлт, цаашлаад ажлын байрыг нэмэгдүүлэх, татварын баазыг өргөтгөхөд чиглэсэн алхам юм. Одоогийн мөрдөж буй албан татварын хувь, хэмжээ нь аж ахуйн нэгж, байгууллагыг 30 хувийн шатлалаас зайлсхийхэд хүргэж Монголын эдийн засагт татварын зөвхөн нэг шатлалд хамрагдах олон жижиг аж ахуйн нэгж, байгууллага давамгайлах нөхцөлийг бүрдүүлж байна.
- Албан татварын амралт, хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг эдийн засагт үр ашиггүй байдлыг бий болгож буй болон хэрэгжих боломжгүй заалтуудыг хаслаа. Харин эдгээр татварын хөнгөлөлтийн оронд тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаадын болон дотоодын бүх аж ахуйн нэгж, байгууллагуудад хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт ижил түвшинд эдлүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа. Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлж буй этгээд, тахир дутуу ажиллагсадтай аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэвээр үлдээсэн юм.
- Хуулийн нэрийг мөн өөрчлөх нь зүйтэй гэж үзлээ. Одоогийн мөрдөж буй хуулийн аж ахуйн нэгж гэсэн ойлголтод ашгийн төлөө аж ахуйн нэгжийг ойлгож ирсэн. Иймд өргөн барьсан хуулийн төслийн нэрийг "Хуулийн этгээдийн орлогын албан татварын хууль" болгон өөрчилж ашгийн болон ашгийн бус этгээдийн ялгааг тодорхойлж өгсөн юм. Уг нэр нь шинэчлэн баталсан Иргэний хуультай нийцэж байгаа бөгөөд бүх хуулийн этгээдийг тэдний статусаас үл хамааран энэ хуульд хамааруулан ойлгох юм.

Дараагийн дугаартаа энэхүү өргөн барьсан хуулийн зарим зүйлүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээнэ.

Татвар төлөгчид өргөн барьсан хуулиудын төслийг "Нээлттэй засаг" вэб сайт www.open-government.mn (Монгол, Англи хувь) болон Улсын Их Хурлын вэб сайт www.parl.gov.mn (Монгол хувь)-аас үзэж болно. Иргэдээс санал авах зорилгоор дор дурдсан вэб сайтаас гадна олны танил болсон бусад вэб сайтуудад уг нийтлэлийг мөн гаргаж байгаа юм. Та бүхэн санал, сэтгэгдлээ үлдээнэ үү.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэчлэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн арваннэгдүгээр хэсэг юм. Та бүхэн уг цувралын электрон хувилбарыг "Нээлттэй засаг" вэб сайт (www.open-government.mn), Сангийн яамны вэб сайт (www.mof.pmis.gov.mn), ҮТЕГ-ын вэб сайт (www.mta.mn)-аас үзэж, саналаа ирүүлж болно.